



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаал, 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн I/421 тоот мэдэгдэл, "Бумбат алтай" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Бумбат алтай" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Бумбат алтай" ХХК /Ш.Батжаргал/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР